



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/116

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэд, өсвөр үе, залуучуудыг тамхинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт электрон тамхи буюу вейп түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулж буй аж ахуй нэгжүүдэд хяналт тавьж, нийтийн болон хувийн эзэмшлийн барилга, байгууламж, объектын хана, зам талбайд байршуулсан электрон тамхины хэрэглээг сурталчилсан далд агуулга бүхий сурталчилгааны самбар байршуулахгүй байх, мөн цахим орчноор хууль бус зар сурталчилгааг түгээхгүй байхад хяналтад тавьж, хор хөнөөлийн талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зөвлөгөө мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах 1 сарын хугацаатай нөлөөллийн аян зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

(Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

(Хууль, эрх зүйн хэлтсийн Хүний эрх, хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого зохицуулалт хариуцсан хуулийн мэргэжилтэн)

(Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга)

(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

(Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)

(Соёл, урлагийн газрын дарга)

(Цагдаагийн газрын дарга)

(Төрийн үйлчилгээ мэдээллийн төвийн ахлах ажилтан)

(Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга:

(Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

(Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт, сурах бичих, сургалтын орчин хариуцсан мэргэжилтэн)

2. Аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган, сум байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг татан оролцуулахыг ажлын хэсэг (Г.Сурмаа)-т даалгасугай.

3. Холбогдох хууль тогтоомж болон захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР